



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/176

Хэрлэн сум

**Ойн баяр, наадмыг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хэнтий аймгийн Норовлин сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын хугацааг 2024 оны 07 дугаар сарын 17-оос 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрүүдэд, Бэрх тосгоны түүхт 70 жилийн ойн баяр наадмын хугацааг 2024 оны 08 дугаар сарын 08-аас 2024 оны 08 дугаар сарын 10-ний өдрүүдэд тус тус тэмдэглэхээр баталсугай.

2.Баяр наадмыг тогтоосон хугацаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Норовлин сумын Засаг дарга (А.Мөнхбайгаль)-д, Бэрх тосгоны захирагч (Ч.Энхжавлан)-д тус тус даалгасугай

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ